



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 4/26

Мандалговь


Газар эзэмших эрхийн гэрчилгээний
дуудлага худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дах заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Сайнцагаан сумын 2020 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сайнцагаан сумын 3-р багийн нутаг дэвсгэр Цагдаагийн постны зүүн талд, 9-р багийн нутаг дэвсгэр Их тойруу-8-815 тоотын баруун талд орших тус бүр 1200м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдааг явуулах хугацаа, тавигдах шаардлага, нөхцлүүдийг тодорхойлон нийтэд зарлан мэдэгдэж, хэрэгжүүлэх ажлыг газрын даамал (Л.Мөнхсарнай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ